



Үндэсний социализм & радикал исламизм

Дашидоржийн Баярхүү 

Олон улсын харилцааны судлаач, профессор

Улаанбаатар, Монгол Улс

bayardevi@hotmail.com

Хураангуй: “2023.10.07” гэж нэг гайт өдөр түүхнээ бичигдсэн. ХАМАС-ын 50 мянган дайчин үүр хаяарахын цагт Израиль Улсын хил даван орж улаан хядлага үйлдсэн. Израильд энэ хядлагыг Дэлхийн II дайнаас хойш тохиогоогүй хамгийн том холокост хэмээн нэрлэсэн. Яагаад ХОЛОКОСТ? Яагаад гэвэл Дэлхийн II дайны үед Германы нацистууд Европт энэ ард түмний эсрэг тоо томиггүй их яргалал үйлдэн аймаглан устгасан. Тэр яргаллыг тухайн үедээ хамгийн ихээр уухайлан дэмжиж, уриалан дуудсан нь Араб, Ойрх Дорнодын мусульманчууд, тэдний оюун санааны удирдагчид болох лалын лам нар. Өнө мөнхийн өст дайсныг нь Гитлер устгаад өгсөн учраас тэгсэн. Энэ тухай түүхэн ямар учир холбогдол байдаг, тэд дайны өмнө ба дайны үед, дайны дараа хэрхэн хамтран ажилласан түүхийг дор өгүүлнэ.

Түлхүүр үгс: нацист үзэл суртал, Араб исламын экстремизм, Ойрх Дорнод, терроризм

Оршлыг орлуулсан өчил

2023 оны намрын тэр үйл явдал Жүүдийн, тэгэх тусмаа Ойрх Дорнодын түүх бичлэгт чухал судлагдахуун сэдэв байх болно. Тэр шөнө, үүрээр, өглөө, өдөр нь ХАМАС-ынхны гарт Алагдсан, эрдэмдэг болсон, хүйс тэмтрүүлсэн, барьцаалагдсан израиль иргэдийн үхэл зовлонгоор Иран ба түүний прокси хүчнүүд ёстой даажигнах шиг болсныг бид мартаагүй. ХАМАС, Хезболла, Йеменийн хуситууд, Ираны аятолла ба Лалын хувьсгалыг хамгаалах корпус, Сирийн исламистууд, Иракийн шиитийн хүчнийхэн бүгд баяр бахдал болон Жүүдийн төрт-улсыг устгах аян дайндаа нэгэн зэрэг мордоод өнөөг хүртэл салаа салбар нь тулалдсаар байна. Израиль нь нэгэн зэрэг 5 фронт дээр тулалдаад түүндээ ялаад сөхөршгүйгээр өнөөг хүргэжээ. Гэхдээ л “2023.10.07”-ны хор уршиг, үр дагавар нь одоо ч олон мянган жүүд хүний сэтгэлийн үүрдийн шарх болон аниж өгөхгүй байна.

Ийм фонон дээр энэ “2026 он”-ыг авч үзэх хэрэгтэй болов уу. Ираны ба түүний прокси хүчний эсрэг АНУ, Израилийн хамтарсан операц бол ойлгомжтой. Харин тийм дайны цаад уг сурвалж, үндэс, үзэл суртал (үзэл санаа) нь юу

вэ гэдгийг дор нягтлахыг хичээлээ. Түүхэн угшлыг нь үлэмж дээр үеэс ухаж гаргалаа.

Дорнод Иерусалим дахь Палестины автономит нутаг дэвсгэрт 1999 онд хэвлэж худалдаанд гаргасан “Миний тэмцэл” (Mein Kampf) номыг Каирт би нэг араб танилаасаа олж үзсэн юмсан. Тэр ном 10 орчим ам.доллартай дүйцэх израиль шекелиэр гялалзтал зарагдаад бүр бестселлер болсон ба одоо ч арабчуудын дунд эрэлттэй байгаа гэсэн. Өмнөх үг нь “Адольф Гитлер хэзээ ч мартагдахгүй, тэр герман үндэстэнд үл хамаарна, учир нь тэр дэлхийн хүн учраас дэлхийд хамаатай” гэсэн өгүүлбэрээр эхэлжээ. Бүх дэлхийн түүхэнд хувь нэмрээ оруулсан энэ түүхэн хүнийг ойлгох хэрэгтэй гэсэн уриалга дагалджээ. Ойлгохын тулд “Үндэсний Социализмын Евангел” болох Mein Kampf-ыг судлагтун, уншигтун, Гитлер үхсэнээр Үндэсний социализм огтхон ч мөхөөгүй юм гэсэн мөрүүд ярайж харагдана. Тэр оршил үгэнд бичсэнээр бол, Гитлер нь эмгэнэлээр дүүрэн, хамаг юмаа устгуулсан, домог болсон жирийн цэрэг, Гитлер нь үзэл суртал, үзэл суртлын асар их өв сан, өв сан нь улс төр, нийгэм, шинжлэх ухаан, соёл тэр чигтээ байх аж.



Түүний өдүүлсэн дайн бол мөн л тэр чигтээ шинжлэх ухаан, соёлын өв гэнэ. Тухайн үедээ Багдадын номын мухлагуудад Саддам Хусейны ботиудтай зэрэгцээд *Mein Kampf* битүү

чигжээстэй, Гитлерийн амьдрал тэмцлийн тухай Хусейны өөрийнх нь бүтээл ч бестселлер болж байсан гэлцдэг. Үүнд тайлбар болгож судалгааны дараах өгүүллээ туурвилаа.

Нэг. Ойрх Дорнодоос колони хайсан түүх

Хүн төрөлхтөнд, ялангуяа европчуудад нацистуудын учруулсан асар их хохирлын тухай Дэлхийн II дайны болон Эх орны дайны тэмдэглэлт ойг угтуулан өргөн дэлгэр өгүүлдэг ба үнэлгээ дүгнэлт нь ч ерөнхийдөө адилавар. Европ, Орос, Америк, Израилийн хувьд энэ дайн хийгээд түүнийг өдүүлсэн Германы нацистууд нэг л үнэлгээтэй бол харин Ойрх Дорнодын арабын улсууд, зарим лалын орнуудад огт өөрөөр, бүр эсрэгээр үнэлж дүгнэж байхыг оросын эрдэмтэн Г.Бондаревский, судлаач В.Яременко¹ нар бүтээлдээ дурдаж анхааруулсан байдаг.

Гитлерийн өдүүлсэн дайн, түүний шовинист бодлого Их Британи, Франц руу чиглээд байсан нь Европт Герман тэдэнтэй халз тулах гэсэндээ бус Дэлхийн I дайны ялагдлаа тэр хоёр гүрний мандат дор байсан Ойрх болон Дундад Дорнодоос нөхвөрлөх гэсэн стратегитай нь холбоотой ба үүн дээр жүүд гэж нэг хүчин зүйл нэмэгдэх аж. “Герман, арабчууд бид англи, жүүд гэх нийтийн дайсантай учраас тэдний эсрэг хамтын тэмцэлдээ холбоотон боллоо”² хэмээн Нацист Германы ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга барон фон Вайцзеккерээс Иерусалимын их муфтий Амин аль-Хусейнид 1941 оны 3 дугаар сарын 11-нд бичсэн захидал байх аж.

Түүх 1. Дэлхийн I дайн эхэлж байх үед Герман нь колонийн шинэхэн эзэнт гүрэн болж амжсан байлаа. Нийт 2.9 сая хавтгай дөрвөлжин километр бүхий нутаг дэвсгэрт 12.2 сая хүн ардыг Германы колони эрхшээлдээ авсан байв. Кайзерын Германы өөрийнх нь нутаг дэвсгэрээс даруй 5 дахин их нутаг мэдэлд нь байжээ гэсэн үг. Дайн эхлээд Германы талд ашигтайгаар өрнөв. Франц, Бельги, мөн Оросоос (Балти орчмын нутаг, Крым, Кавказ, Донын хязгаар,

Одесс хот хавь) ихээхэн нутаг дэвсгэр эзлэн авна гэсэн төлөвлөгөөгөөр дайтав. Оросын мэдлийн Дундад Ази, Британийн Энэтхэг рүү хэтдээ довтолно, Ойрх болон Дундад Дорнод нь Германы хувьд найдвартай түшиц газар болох учиртай хэмээн Берлинд үзэж байв. Гэвч энэ лут төлөвлөгөө хэрэгжсэнгүй. Герман ялагдлаа. Германы империализмын колонийн экспанс хийх төлөвлөгөөний эхний үе шат дампуурлаа.

Түүх 2. Версалийн энх тайвны гэрээгээр Герман нь Европ дахь нутаг дэвсгэрийнхээ 1/8, хүн амынхаа 1/12-ийг алдсан ба Антантын гүрнүүдэд далайн чанад дахь эзэмшил, колониудаа хураалгалаа. 1918 онд байгуулагдсан энхийг эрхэмлэгч, ардчилсан Веймарын Герман Кайзерын германы колонийн бодлогоос татгалзсан боловч албан бусаар расист-шовинист, хонзогногч үзэл бодлыг ил далд өөгшүүлсээр байв.

Түүх 3. Колони байсан орнууд нь Германы мэдэлд эргэж орохыг хүссэн тухай 4 сая гарын үсэг цуглуулж, 1928 он гэхэд “Бүх нийтийн колонийн программ” гэгчийг боловсруулж мөрдөж эхлэв. Дэлхийн эдийн засгийн хямрал нүүрлэхийн хэрээр Версалийн гэрээний цэргийн хязгаарлалт суларч, “Амьдрах орон зай”, “Жүүдийн хуйвалдаан”-ы номлол Германаас амилжээ. Колониудаа эргүүлж олж авахгүйгээр улс орон хөгжихгүй гэх үзэл бодол Гитлерийг засгийн эрхэнд гарч ирэх үест Германд хүчтэй түгсэн байлаа.

Түүх 4. Версалийн гэрээнд гомдож өсөрсөн сая сая хүн ардын итгэл сэтгэлийг тээж нацистууд гарч ирлээ. Германы колонийн эзэнт гүрнийг сэргээн байгуулах нь III Рейхийн гадаад бодлогын гол номлол боллоо. Версалийн гэрээ гэдэг нь сионистуудын хуйвалдааны үр дүн хэмээн номлов. “Тухайн цагтаа дэлхий нь

¹ “Arab,” *Polit.ru*, April 26, 2005, <http://polit.ru/article/2005/04/26/arab/>

² Emerson Vermaat, “Haj Amin Al-Husseini — Nazi Collaborator and Model for Today’s Islamists,” *Militant Islam Monitor*, February 27, 2008, <https://www.militantislammonitor.org/article/id/3381>

сионист хуйвалдааны золиос болсон. Энэ хуйвалдаанаар германчуудын амьдрах орон зайг булаан авсан. Тийм учраас түүхэн шударга ёсыг сэргээн тогтоох ёстой” – Геббельсийн суртал нэвтрүүлгийн машины гол уриа нь. “Энэ бол мөнхөд байсан асуудал. Германчууд ба нутаг дэвсгэрийн хоорондын харьцааг зөвөөр тогтоох ёстой. Хэрэгцээт орон зайг нь хангаж өгөх ёстой. Энд даруу зан тус болохгүй. Түүнийг зөвхөн илд мэсний тусламжаар шийдвэрлэх ёстой” – Адольф Гитлер 1939 онд Берлиний залуучуудын цуглаан дээр ингэж хэлжээ.

Версалийн энх тайвны гэрээ байгуулагдсаны гол буруутныг жүүдүүд гээд ийнхүү тодруулаад авлаа. Жүүдүүдийг эсрэг хядлага эхлүүлэхэд буруутахгүй болжээ. Харин жүүдийн эсрэг үзлээ Ойрх Дорнодтой хэрхэн холбох вэ? Эхний шатанд (1) Гитлер худалдааны экспансын зорилгоор Ойрх болон Дундад Дорнод руу нэвтрэхийг зорив. Турк, Сири, Ирак, Иран, Палестин, Египет рүү Германы экспорт 1933-1937 онд 81.5 сая маркаас 250 сая марк болтлоо өсчээ. Нэр бүхий улсууд нь Германы хувьд экспортын 14 хувь, импортын 18 хувь эзлэх ба эл бүс нутагт германы өдий төдий банк, худалдааны пүүс, мөн улс төр-тагнуулын сүлжээ ажиллах болжээ. Британи, Франц хоёр өөрийн мандатын улсууддаа элдэв хориг саад тавиад тавиад тэр шүү дээ. Британи, Францыг хориглох тусам нутгийн ардууд англи-францын колонийн бодлогыг улам бүр зүхэх болж, германыг таашаах бишрэх нь нэмэгджээ. Яг энэ эгзэгтэй мөчид (2) арабын националистуудын антисемитизм (жүүдийн эсрэг үзэл) дээр дөрөөлөн Ойрх Дорнодын анхны фашист байгууллага: “Залуу Египет”, “Сирийн үндэсний үйл ажиллагааны лиг”, “Дамаскийн араб клуб”, ираны Сейф Азаны фашист нам зэргийг Нацист Германаас байгуулж ажиллуулав. Ийнхүү мусульман ард түмнүүдийн дунд Герман улсын үнэмлэхүй имиж бүрдэж, арабын дарлагдсан улс түмэнд зовох цагт нөхрийн чанараа таниулсан чөлөөлөгч нэгэн улс Төв Европоос гарч иржээ.

Арабчуудыг дарлал талхигдлаас чөлөөлөхийн сацуу жүүдүүдийн иммиграцыг чухам Герман л таслан зогсоож чадна. Яаж зогсоох гэдэгт Освенцим, Заксенхаузен, Майданек ... гээд бэлэн жор байна. Нацистууд ба

мусульманчуудын онцгой харилцаа гэдгийг 1940 оноос германы суртал нэвтрүүлгийн машин уйгагүй сурталдаж гарлаа. Францын армид тулалдаж байгаад олзлогдсон магрибын арабын 10 000 дайчдыг германчууд суллан эх оронд нь буцаалаа. Парист алжир цагаачдын тусалцаатайгаар нацистууд араб сонин гаргаж, арабын улс түмэнд III Рейхээс найрсаг хандаж байгаа тухай суртал нэвтрүүлэг хийж, арабчуудыг хөлсний цэрэгт элсүүлж эхлэв. Францад буй мусульманчуудаас германы армид “Умард Африкийн легион” нэртэй тусгай анги байгуулагдаж партизаны эсрэг дайтаж эхэлсэн ба “Францын сайн дурынхны легион”-д францын мусульманчууд олноороо элсэж дорнод фронт руу дайтахаар явжээ.

Энэ бүх ажиллагаа антисемитизмээс үүдэлтэй, учир нь жүүдийн эсрэг Гитлерийн уриа мусульман арабчуудад ихээхэн итгэл төрүүлжээ. Ялангуяа жүүдүүд шилжин очиж, жүүд хүн ам тасралтгүй өсч байсан Палестинд Гитлерийн уриа ус агаар мэт чухал байлаа. Гитлерийн хавчлагаас дүрвэсэн европын жүүдүүдэд “колонист” хэмээх нэр нутгийн арабчууд өгчээ. Хаа явсан газраа амьжиргаатай, овсгоотой, оюунлаг жүүдүүд залхуу арабчуудын хилэнт дайснууд болон хувирчээ. Сирийн үндсэрхэг үзэлтэн аль-Кавкажи гэдгийг тухиран “Палестины аугаа их хувьсгал” гэдгийг 1936 онд нацистууд сэдээд жүүдүүдийг алж талан, тонон дээрэмдээд дарагдав. Тэгэхлээр нь Нацист Германы ГХЯ-наас 1941 онд Британийн колони арабын орнуудад сэтгэхүйн дайн явуулах тусгай төлөвлөгөө батлан хэрэгжүүлэв.

Суртал нэвтрүүлгээс эхлээд хорлон сүйтгэх террорист бүх ажиллагааг эндээ тусгав. Германы ГХЯ-ны болон абверын төлөөлөгчид Араб дорно дахинаар хөлхөж байлаа. Нутгийн арабчууд тэдний заавраар англи-жүүдийн эсрэг хорлон сүйтгэх, германы онгоц нисч буух талбай байгуулах хамгаалах ажил эрхлэхийн сацуу Квенцгүт гэдэг газар абверын тусгай алба

араб агентуудыг бэлтгэж байв³. Араб дорно дахинд нацистууд чөлөөтэй ажиллах болсонд Их Британи нүдэн балай өнгөрсөнгүй. Колонийн асуудлаар 1937 оны 2 дугаар сард Лондонд Риббентроп, лорд Халифакс нарын хооронд явагдсан хэлэлцээ анхаарал татдаг. Хэрэв Герман нь Африк дахь хуучин колониудаа 10 жилийн турш нэхэхгүй, Ойрх Дорнод дахь мандатын тогтолцоо руу 10 жилийн турш өнгөлзөхгүй байх баталгаа өгөх аваас хариуд нь Дорнод Европт чөлөөтэй ажиллах эрхээр хангагдана хэмээн британичууд буулт хийж байжээ. Франц юу юугүй буугаад өгснөөрөө Алжир, Марокко, Тунис дэх цэргийн баазаа Германд алдаад зогсохгүй, 1942 онд Вермахтын “Африк корпус”-ыг Египет рүү давшуулах

үүдийг нээв. Франц ялагдсанаар Ойрх Дорнод дахь Британийн байр суурь сулрав. Англи-Египетийн харилцаа аяндаа ганхлаа. Харин ч Германтай холбоотны харилцаа тогтоохыг дэмжигчид Каирт бэхжив. Англи-Египетийн харилцааны зөрчил дээр Гитлер тоглолт хийн Герман-Британийн хооронд гэрээ байгуулах санал дэвшүүлэв. “Дэлхийн аль ч өнцөг буланд германы зэвсэгт хүчнээр Британийн эзэнт гүрнийг хамгаалах” үүрэг хүлээх тухай тэнд нь тусгажээ. Ингэснийхээ хариуд Гитлер Данциг, “польшийн коридор” гэдгийг Германд шилжүүлэх, Польш дахь герман цөөнхид эрх эдлүүлэх, мөн колонийн асуудал дээр бяцхан буулт хийхийг британичуудаас шаардав.

Хоёр. Гитлер – зөнч Мухаммедын удам!

1937 онд Гитлерюгенд хөдөлгөөний дарга нэрт нацист Бальдур фон Ширах арабын хэд хэдэн улсаар аялан айлчлав. 1939 онд Каирт Йозеф Геббельс морилов. Дайны өмнөхөн Адольф Эйхман Палестинд очиж, жүүдийн эсрэг үзэлт арабын үндсэрхэг үзэлтнүүдтэй уулзав гэхчлэн баримт жагсаавал нэлээд олон гарч ирэхээр юм.

1940 оны эхээр Иракт засгийн эрхийг Рашид аль-Гайланийн Засгийн газар авмагцаа Анкара дахь германы Элчин сайд Папентай харилцаа тогтоож, хэдэн жилийн турш хамтран ажилласан ба “Умард Арабын эзэнт гүрэн” байгуулах төсөл хамтран хэрэгжүүлэхийг зорьжээ. Багдадын удирдлагын дор буй болох тийм эзэнт гүрнийг “Тэнхлэгийн” гүрнүүд ивээн тэтгэх ёстой аж. Чингэхдээ британийн титэм, жүүдийн колоничлолоос арабын ертөнцийг чөлөөлөхийн төлөө Британийн эсрэг чөлөөлөх дайн хийж дэмжинэ гэсэн үг. Энэ асуудлаар 1940 оны 12 дугаар сард Германы ГХЯ-нд тусгай зөвлөлгөөн хийжээ. Ярилцсан сэдэв гэвэл: “Арабчуудын үндэсний, цэргийн, соёлын, төрийн байгуулалтын хүчийг дутуу үнэлж болохгүй”, “Жүүдийн эсрэг үзлийн үндсэн дээр арабчуудтай эвсэх”, “арабчууд бол Өмнөд ба

Дорнод Ази, Дорнод Африк руу хүрэх зам дагуухи чухал гүүр, хүчин зүйл мөн болох”, “Тэд бол даян дэлхийн лалын шашны үндсэн төлөөлөгчид мөн бөгөөд тэдэнд Германы өсөн дэвшиж буй аж үйлдвэрийг тэтгэх нефтийн асар их нөөц байдаг”⁴ тухай ярилцжээ.

Төд удалгүй Берлинд Иерусалимын их муфтий Хаж Амин аль-Хусейнийн хувийн нарийн бичгийн дарга Осман Хаддадыг хүлээн авчээ. Тэрээр германы нэрт тагнуулч, хожим Багдадад “Элчин төлөөлөгч”-өөр очсон Гробба гэгчтэй хэлэлцээ хийхдээ, “Тэнхлэгийн” гүрнүүдтэй хамтран ажиллах нийт арабын хороо гэдгийг “арабын лидерүүд” байгуулсныг уламжлаад, Ойрх Дорнодын нефтийг ашиглуулах давуу эрх Германд олгох болсноо мэдэгджээ. Ингэсний хариуд Герман, Итали хоёр “Арабын улсуудын тусгаар тогтнолын тухай тунхаглал” гэгчийг хэвлэлд нийтэлж зарлах ёстой байв.

Нэлээд дээхнээс III Рейхийн хүндэт зочин болсон Иерусалимын их муфтий аль-Хусейни⁵ гэгчийг энд зориуд нэрлэх нь зүйтэй. 1929 онд Иерусалимд жүүдүүдийн эсрэг арабчууд цуст халдлага үйлдсэний дараа британийн цэргийн

³““Nazism, Islam Shared Common Enemies — the Jews,”” *The Jerusalem Post*, December 15, 2010, <https://www.jpost.com/international/nazism-islam-shared-common-enemies-the-jews/article-199451>

⁴ Emerson Vermaat, “Haj Amin Al-Husseini — Nazi Collaborator and Model for Today’s Islamists,” *Militant Islam Monitor*, February 27, 2008, <https://www.militantislammonitor.org/article/id/3381>

⁵ Палестины Чөлөөлөх Байгууллагын дарга, Палестины автономит засаг захиргааны Ерөнхийлөгч Ясир Арафат нь энэ муфтийн зээ дүү байсан тухай баримт түгээмэл байдаг.

шүүх энэ муллад 10 жилийн ял өгсөн байдаг. Тэрээр ялаа эдлэлгүй бултаж алга болсон ба хожим өршөөгджээ. Англичуудыг гарсны дараа Палестины төрт-улс байгуулах бэлтгэлийг тэр үеэс аль-Хусейни нь эрчтэй хийж, 1936 онд Арабын дээд зөвлөл гэдгээ байгуулан, жүүдүүдийг Палестинд ирүүлэхийг зогсоохыг английн захиргаанаас шаардаж байв. Шаардлага үл хэрэгжсэнээр барахгүй их муфтий өөрөө хүчгүйтэн Бейрут руу дүрвэж, тэндээсээ Сири, Ирак, Иранаар дамжин 1941 оны зун Берлинд хүрчээ. Багдадад байхдаа 1941 оны нэгдүгээр сарын 20-нд Гитлерт хаяглан бичсэн захидал⁶ нь эдүгээ ил болжээ. Тэрээр эд материал, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх аваас арабчууд Британийн эсрэг тэмцлээ эхлүүлэх шийдвэр төгс байгааг илэрхийлжээ. Нацист Германы ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга барон фон Вайцеккер Гитлерийн даалгавраар их хамбад хариу захидлыг 1941 оны 4 дүгээр сарын 8-нд бичжээ. Арабчуудад Германаас санхүүгийн болон цэргийн тусламж үзүүлэхээр үл барам хэрэв хүргэх зам чөлөөтэй бол зэр зэвсэг нийлүүлэхээр төлөвлөж байна. Зэвсэг хүргэх зам нээхийг Иракийн Ерөнхий сайд Рашид Али аль-Гайланид санал болгох болно. Иракт британийн цэрэг орсны хариуд Герман Иракт зэвсэг нийлүүлж, “30 өдрийн дайн” гэсэн кодлосон нэрээр англичуудын эсрэг байлдааны ажиллагаа эхлэнэ гэхчлэн тэр захидалд дурджээ⁷.

Зөвлөлт Холбоот Улстай их дайн эхлүүлэхийн өмнө Британитай Ойрх Дорнодод томхон мөргөлдөөн дэгдээхийг Берлинд түвдсэнгүй, гэвч “болгоомжтой, гэхдээ тууштай” ажиллахыг Гитлер үүрэгджээ. Амласан ёсоороо арабчуудад олзны зэвсэг, мөнгө илгээв. Арабчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг тууштай дэмжинэ гэдгээ 1940 оны 10 дугаар сарын 23-нд араб хэлээрхи радиогоор дэлхийд зарлав.

Энэ үеэс эхлэн гадаад нэвтрүүлэгт нь араб хэлний хэлний нэвтрүүлэг байнгынх боллоо.

Тэр нэвтрүүлгээр нь арабчуудын толгойг эргүүлэм элдэв мэдээлэл хөвөрч өглөө. “Гитлер лалын шашинд орсон” тухай, “Гитлер нь зөнч Мухаммедын удмын садан төрөлт мөн” болох тухай, “лалд үнэнч лалын төлөө тэмцэгч Гитлер бол арабчуудын цорын ганц найз болох” тухай, “тун ойрын үед арабын тусгаар тогтносон федерац байгуулахыг Гитлер тууштай дэмжиж байгаа”⁸ гэхчлэн уйгагүй сурталдав. Гол нь энэ сурталд нь ихэнхи арабчууд чин сэтгэлээсээ үнэмшив.

Англичуудын шахалтаар Иракийн Ерөнхий сайд аль-Гайлани 1941 оны эхээр огцорсон боловч германчуудын тусалцаатайгаар 4 дүгээр сард нь төрийн эргэлт хийж засгийн эрхийг эргүүлэн авав. Английг үзэн ядагч иракчуудын дийлэнхи нь түүнийг дэмжлээ. Тэр үед Берлинээс тусгай элч Гробба Багдадад очиж, арабчуудын бүх нийтийн бослогын төлөвлөгөөг танилцуулав. Гроббын араас генерал Гельмут фон Фельми тэргүүтэй цэргийн төлөөлөгчдийн томхон баг очиж, “F”-онцгой штаб нэрээр ажиллах ёстой байв. Энэ штабыг Дээд ерөнхий командлалын газрын (дарга нь Гитлер) № 32 “Ойрх Дорнод” (1941.05.23) хэмээх захирамжаар байгуулжээ. “F”-онцгой штабын үүрэг нь тодорхой. Иракийг Вермахтын түшиц газар болгохоор бэлтгэх, “Мессершмитт”, “Хейнкель” маркийн 60 нисэх онгоц нэг зэрэг нисч буух зурвас байгуулах, тэр онгоцуудаар арабчуудын зэвсэг байлдааны техникийг зөөж очихоор төлөвлөжээ. Ингэх мөртлөө арабчууд Их Британид дайн зарлах ёстой. Аль-Гайлани зарчмын хувьд энэ саналд зөвшөөрсөн хариу өгсөн боловч хэрэв герман ялбал өөрөө Гитлерийн гарын тоглоом болж хувирна гэдгээ ч ойлгож байв.

Гэтэл төлөвлөгөө өөрөөр эргэв. Балканд Вермахт дайтаж байсан, СССР руу Герман хэзээ мөдгүй довтлох гэж байсан агшныг англичууд ашиглав. Генерал Фельми сирийн Халев хотод дөнгөж очоод байхад нь Ирак дахь профашист эргэлтийг британийн цэрэг дарав. Иракийн

⁶ Sam Roberts, “Declassified Papers Show U.S. Recruited Ex-Nazis,” *The New York Times*, December 11, 2010, <https://www.nytimes.com/2010/12/12/us/12holocaust.html>

⁷ Ibid.

⁸ David Irving, “Did Himmler Ever Admit to ‘Three Million’?,” *Focal Point Publications*, accessed June 2, 2026, https://fpp.co.uk/Himmler/Judenfrage/Mufti_memoirs.html

Ерөнхий сайд, иерусалын муфтий нар Иран руу дүрвэв. “Гитлер–зөнч Мухаммедын удам!” гэдэг үзэл суртлыг үлэмж түгээдэг, ялалтыг нь уухайлдаг нийгмийн тодорхой бүлэг Иранд байсан учраас тийшээ дүрвэсэн хэрэг л дээ. Одоо нэгэнтээ тодорхой болсон баримтаар бол хожмын Ираны лалын хувьсгалын удирдагч аятолла Хомейни болбаас дэлхийн II дайны үед улс төрийн сэжиг бүхий нэгэн байсан ба Жүүдийг үзэн ядагч, нацизмыг талархагч гэдгээрээ Ирандаа алдаршсан аятолла Наваб

Сафави болон алан хядах нууц байгууллагын толгойлогч Аболькасем Кашани нартай хамтран ажиллаж байсан ажээ. Жүүдийг үзэн ядах хар зөн нь тэднийг Германы нацистуудтай нөхөрлүүлжээ. “Жүүдийн төр улсыг (Израиль) газрын хөрснөөс арчиж хаяна, нацистууд II дайны үед жүүдүүдийг аймаглан устгасан нь зөв, гэхдээ холокост энэ тэр гэдэг чинь шал зохиомол” хэмээн Ираны хожмын Ерөнхийлөгч М.Ахмадинежад үе үе айлддаг байсансан. Одоо ч тэгж яриад явж байдаг биз ээ.

Гурав. Захирамж № 32

“Барбароссын төлөвлөгөө” буюу Зөвлөлт Холбоот Улс руу Нацист Германы халдсан байлдааны ажиллагаатай бараг зэрэгцээд “Захирамж № 32” гэдэгт Гитлер гарын үсэг зурсан байдаг. СССР дайнд ялагдаад, түүний нутаг дэвсгэрт “Германы Энэтхэг” хэмээх шинэ улс байгуулахтай зэрэг Британийн Ойрх Дорнодын эзэмшил рүү шилжиж орно хэмээн “Захирамж № 32”-т заагаад энэ бэлтгэлийг хангахын тулд 1941 оны 4 дүгээр сард Германы хуурай замын цэргийн штабын дарга хурандаа генерал Ф.Гальдерын тушаалаар “оперативын бүлэг” байгуулж эхэлжээ. Энэ бүлэг нь Испанийн Марокко, Умард Африк, Египет, Анатоли, Афганистаныг эзлэн авах ба энэ дайндаа 60 дивиз, агаарын нэг флотыг Зөвлөлтийн нутгаас татаж оролцуулах аж. “Төлөвлөгөө хэрэгжүүлж дууссаны дараах үеийн бэлтгэл ажил” хэмээн баримт бичигт 1941 оны 6 дугаар сарын 11-нд Гитлер гарын үсэг зуржээ. Түүнд зааснаар бол, Газар дундын тэнгис, Бага Ази дахь британийн байрлал руу Египетээр дамжин Ливис, Туркээр дамжин Болгараас, мөн нөхцөл байдлаас шалтгаалан Иранаар дамжин Өвөр Кавказаас бөөн хүчээр атаклах, Умард Африкт Тобрукийг эзлэн авч, Суэцын суваг руу хийх герман-италийн цэргийн давшилтыг хангах, Суэцын сувагт британийн цэргийг бутцохих, Өвөр Кавказаас Иракийн эсрэг моторжуулсан аян замын корпус илгээх, энэ хэрэгтээ “арабын хөдөлгөөн”-ийг идэвхтэй ашиглах, германы ажиллагааны дүнд Ойрх Дорнодод англичууд хүнд байдалд орно, гэвч үүнд нь нутгийн араб хүн амын үймээн самуун, бослого чухал үүрэгтэй гэж үзэх, цэрэг-улс төр,

суртал нэвтрүүлгийн бүхийл үйл ажиллагааг энэ зорилгодоо зохицуулах, Арабын бүс нутагт бүх төлөвлөгөө, үйл ажиллагааг удирдах төв байгууллага нь “F”- онцгой штаб байх болно, штабыг Зүүн өмнөд дэх цэргийн ерөнхий командлагчийн мэдлийн районд байрлуулах, хамгийн шилдэг мэргэжилтэн, агентуудыг тийш нь илгээх тухай заажээ.

Ийнхүү Ойрх Дорнодод явуулах томхон дайнаа Герман эхлүүлээ. Цэргийн талаас Вермахтын нэгдсэн командлалын Кейтельд захирагдаж, улс төрийн талаас Риббентроп залж чиглүүлнэ, гурав дахь захирагч нь “Элчин төлөөлөгч” Гробба. 1941 оны 9 дүгээр сарын 21-нд Кейтелийн гарын үсэг зурсан зааварчилгаагаар Арабын говь цөлийн нөхцөлд байлдах онцгой зориулалтын № 287, № 288 механикжуулсан тусгай хоёр нэгтгэл байгуулав. № 287 нэгтгэлд нутгийн арабчуудыг элсүүлэхээр болж 2200 цэрэг офицер бүхий ангийг Потсдамд байгуулан мөдхөн Умард Африк руу илгээжээ.

1942 оны 8 дугаар сар гэхэд германы цэрэг Кавказын бэлд, Роммелийн цэрэг Александриа хотоос 100 км тулж ирсэн, хэзээ мөдгүй Тбилиси эзлэгдэнэ, тэндээсээ Ирак руу давшилтаа Вермахт эхлүүлнэ гэсэн итгэл арабчуудад төрсөн байлаа. “F” хэмээх онцгой штабаа корпус болгон зохион байгуулж, Сталино (өнөөгийн Донецк) хотод байрлуулав. Корпусын бүрэлдэхүүнд арабт дайтах 6000 цэрэг бэлэн болсон байлаа. Тэдэн дээр танкийн батальон, морин цэргийн хороо, бусад анги салбаруудыг нэмж өгөв. Лалын бэлгэдэл, халуун орны далбуу мод, цөлийг дүрсэлсэн таних тэмдэг бүхий

герман, мусульман цэргүүд Украинд тушаал хүлээн суулаа. Төлөвлөснөөр бол тэд эхлээд Тбилисийг эзлэн авна. Тэндээсээ Кавказыг давна. Тэндээсээ Баруун Иранаар дамжин Басра хотын чиглэлд Ирак руу давшина. Иран-Иракийн хил давагцаа колонийн боолчлолоос арабчуудыг чөлөөлөх чөлөөлөгийн үүргээ гүйцэтгэнэ. Гэвч энэ төлөвлөгөө цаасан дээрээс

халиагүй, нөгөө корпус нь “А” хэмээх армийн бүлэглэлийн дорнод жигүүр болон Моздокийн хавьд Улаан армитай тулалдаанд орж ялагдал амсав. 1942-1943 оны өвлийн байлдааны явцад зөвлөлт-германы фронт дээр Вермахт үхлийн цохилт хүлээж, Гитлерийн Ойрх Дорнодын төлөвлөгөө нурав. Германы колонийн бодлогын хоёр дахь үе шат үүгээр дампуурав.

Дөрөв. Нацистын бөөнөөр хорих лагериудын хүндэт зочид

Ойрх Дорнод руу хийх байлдааны бэлтгэлтэй нь зэрэгцэн арабчуудыг дэмжих улс төрийн ажил Германд ид өрнөсөн юм. 1941 оны 11 дүгээр сарын 28-нд Берлинд Иерусалимын их муфтий Гитлерт бараалхав. Британийн эсрэг дайнд Германтай хамтрах “Араб легион” байгуулахад бэлэн байна, харин хариуд нь Герман улс муфтий аль-Хусейни даргатай араб улсын тусгаар тогтнолын тунхагийг зарлан тунхаглах ёстой хэмээн лалын их хамба нацистын жолоодогчид санал болгов. Саналыг Гитлер хүлээн авсангүй. Түүнийгээ Верхамт Умард Кавказ руу хүрч чадахгүй, зууртаа хүнд ширүүн байлдаан өрнүүлж байна, ерөөсөө Иракт очиж бэхжиж чадахгүй байхад араб улсын тусгаар тогтнолын тунхагийн тухай яриа байж таарахгүй хэмээн тайлбарлав. Харин “Араб легион” байгуулах саналыг ойлгон хүлээн авангаа, “F” штабын дэргэд тэр легионоо байгуул, эсвэл ирак-арабын арми гэж нэрлэ, бүрэлдэхүүнд нь иракийн 3 дивиз, сири, палестин-иорданы нижгээд нэг дивиз (нийт 5 дивиз) байгуул хэмээн үүрэгджээ. “Германд сэтгэл харамгүй тусалсны” хариуд сар бүр 75 мянган маркийн цалин олгож байхаа Гитлер их хамбад амлажээ.

Иерусалимын их муфтийн мөрөөр Иракийн Рашид аль-Гайлани 1941 оны 12 дугаар сард Берлинд очив. Риббентроп хүлээн авч хэлэлцээ хийв. Араб улсын тусгаар тогтнолын тунхагийг муфтийд татгалзаж байсан атлаа энэ удаа арай зөөлнөөр ханджээ. Рашид аль-Гайланийг Иракийн Ерөнхий сайд мөн хэмээн хүлээн зөвшөөрч, Ирак-Германы хоорондын ирээдүйн хамтын ажиллагааны тухай хэлэлцэхэд бэлэн байна хэмээн Риббентроп бичгээр баталгаа гаргаж өгчээ. Эндээс үзвэл III Рейх палестины экстремист ламыг бус, иракийн улс төрчийг

илүү эрхэмлэж байсан юм уу гэмээр. Муфтий ч ивээн тэтгэгчээ эрсээр Ромоос олжээ. Аль-Хусейнийг Муссолини санаандгүй дэмжив. “Арабын их төрт-улс” гэгчээ Ирак, Трансиордан, Сири, Ливан, Палестиныг оролцуулан өөрийнх нь удирдлага дор байгуулах саналаа их хамба Муссолинид уламжлав. Гэвч Италийн хувьд Араб ертөнцийн гол түлхүүр Египет чухал, Египет рүү халдан довтлохын тулд Италид Ойрх Дорнодын төлөвлөгөө чухал байв.

1942 оны зун Амин аль-Хусейни италийн цэргийн тагнуулынханд дахин хандав. Өөрийнх нь удирдлага дор Умард Африкийн суртал нэвтрүүлгийн төв ажиллах юм гэнэ. Харин Гитлер Египетэд хоёрдугаар зэргийн ач холбогдол өгч байснаас Муссолинийн дэмжлэг Аль-Хусейнид төдийлөн очсонгүй. Арабчуудыг Зөвлөлт Кавказ, Иран, Туркээр дамжин эзлэн авна гэх Германы байр суурь иерусалимын их хамбыг саармагжуулжээ. Дорнод фронтод “А” хэмээх армийн бүлэглэлийн бүрэлдэхүүнд “Кавказ-Иран” гэх оперативын бүлгийг байгуулжээ. Түүндээ Иракийн нефтийн районуудыг эзлэн авах үүрэг бүхий танкийн хоёр, явган цэргийн нэг, уулын буудлагын хоёр дивиз байгуулав. Аль-Хусейни горьдлого тасарсангүй, Герман руу хандсаар байв. Иракийн аль-Гайланитай хамтран ажиллаад хохирол амсана, үр дүн гарахгүй гэж ятгаж ч үзэв. Тэр ч бүү хэл Иракаас өөр мэдлэггүй Гробба ноёотноо Берлинд матаж үзэв. Ерөөсөө Ойрх Дорнодын араб ертөнцийн эзэн өөрөө гэсэн үзлээ муфтий тулгасаар. Тэрээр британийн эсрэг, жүүдийн эсрэг нууц байгууллагын удирдагч төдийгүй, араб улс дундын “Мусульманы конгресс”-ын ерөнхийлөгч, тэр утгаараа арабын орнуудад аль-Гайланигээс илүү

эрх мэдэл нөлөөтэй хэмээн нацистуудыг ятгав. Аман ятгалга бус ажил хэргээрээ ч өөрийгөө лалын нацист (исламофашист) болохоо нотлон харуулав. Югославын боснийн мусульманчуудаас “Ханжар” хэмээх СС-ийн уулын 13 дугаар дивиз бүрдүүлж өгөв. Вермахт, СС-т шинээр бүрдүүлсэн лалын шашинт цэргийн ангиудыг жүүдийн эсрэг баривчилгаа, хомроглол, аллагад өргөн ашиглаж байв.

1943 онд Аль-Хусейни Риббентропоос шаардсаар байж 5000 жүүд хүүхдийн дүрвэлтийг Болгарт зогсоолгон, Палестиныг жүүдийн цагаачдаас гэтэлгэв. Цаад 5000 хүүхэд нацистуудын гарын шүүс амсав. Тель-Авивыг бөмбөгдөх, тийш нь германы шүхэрчдийг буулган байлдуулахыг Германаас ятгав. 1944 оны 3 дугаар сарын 1-нд Берлиний радиогоор лалын бүх ертөнцөд хандан жүүдүүдийн эсрэг жихад явуулахыг уриалав. “Арабчууд аа, нэг хүн шиг босцгоогтун! Ариун эрхийнхээ төлөө тэмцэгтүн! Жүүдүүдийг алаад бай, эрээд олдохгүй болтол нь алаад бай! Энэ бол бурхан, түүх, шашинд чинь хэрэгтэй! Ингэвэл Та нарын нэр хүнд аврагдана!”⁹— Берлиний радиогоор түүний хэлсэн үг. Тэрээр нацистын бөөнөөр хорих лагериудын хүндэт зочин байлаа. Хичнээн жүүдийг хэрхэн яаж алж устгасан тухай яриулж сонсож, нүдээрээ харж суух нь түүний чин сэтгэлийн хүслэн байлаа.

Тав. Арабын национализм & нацизм

Англи-францын колоничлогчдоос салж тусгаар тогтнолоо олж авахад нь нацистын Герман гол өмөг түшиг байх тухай нийгмийн сэтгэхүй Араб дахинд хүчтэй тархсан яг тэр үед дэлхийн II дайн дуусчээ. Арабчуудын итгэлийн гал хамт мөхлөө. Гэвч тэднийг холбох өөр нэг бат бэх холбоос үлджээ. Жүүдийн эсрэг нацистуудын уриа лоозон араб мусульманчуудын сэтгэл зүрхэнд мөнхрөн үлджээ. Тиймдээ ч II дайны дараа нацистын гэмт хэрэгтнүүд үй олноороо Египет, Сири, Ирак, Судан, Саудын Араб, Йемен, арабын бусад улс руу дүрвэн гарч толгой хоргодсоны шалтгааныг мэдэж цөхөх юмгүй. Нюрнбергийн олон улсын шүүхийн шийдвэр

Аль-Гайлани ч хамбаас дутахгүй Берлинд үнэнчээ илтгэн, элдвээр ятгахаа мартсангүй. Аль-Хусейнид таагүй ханддаг сири, палестин, ливан, иракийн нөлөө бүхий үндсэрхэг үзэлтнүүдийг нэгтгэн өөрийн намаа байгуулан Арабын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагч болох бэлтгэлээ базаав. Хошууч Кавкажи, берлиний радиогийн араб хэлний нэвтрүүлгийн тоймч Юнис Бахри нар Гайланийн үнэнч туслагчид болов. Тэд албан ёсоор Риббентропт хандан өөрсдийг нь Ойрх Дорнодын албан ёсны эрх баригчид хэмээн хүлээн зөвшөөрч хэлэлцээ хийхийг уриалав. Уриалга хэрэгжив. Абвер болон Дээд ерөнхий командлалын чармайлтаар герман-иракийн цэргийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт Берлинд гарын үсэг зурав. Иймэрхүү хэлэлцээр Амин аль-Хусейнитэй байгуулахыг Гитлер хүссэн боловч цаадхи нь татгалзав. Швейцарьт хувийн сониноо эрхлэн гаргаж байсан сирийн эмир Арслан гэгчийн сонинд дээрхи хэлэлцээрийн зарим заалтыг нийтлэн аль-Хусейни Иракийн Ерөнхий сайд асныг шүүмжлэв. Түүнийхээр бол Иракийн улс төрч нь нийт арабын үйл хэргээс урвасан, “араб эх орны зүрх” рүү сионистууд чөлөөтэй нэвтрэх гарц нээж өгсөн ялтан гэнэ.

жүүдийг үзэн ядагч мусульманчуудад падгүй. Загалмайтан асан нацистуудыг лалын шашинд элсүүлэхдээ арабчууд хөл алдан, цаадуул нь ч хэл үггүй исламд орж, нэрээ сольцгоон амь аврагдав.

Иерусалимын их муфтий Хаж Амин аль-Хуссейни өөрөө биечлэн Заксенхаузен, Освенцим, Майданек зэрэг бөөнөөр хорих лагериудаар явж, жүүд нарыг хэрхэн хүйс тэмтэрч байгааг харж шалгаж явсан баримт хангалтай хэмээн дээр бичсэн билээ. Энэ ажлыг түүнд зориулан зохион байгуулдаг байсан СС-ийн гауптштурмфюрер Бруннер хожим нь муфтийн туслалцаатайгаар ялаас мултарч, Ойрх

⁹ Pamela Geller, “The Muslim Hitler, Haj Amin al-Husseini, Was Promised Leadership of Israel [Palestine] After Annihilation of the Jews,” *Atlas Shrugs*, December 2010, <https://pamelageller.com/2010/12/>

Дорнод руу дүрвэн Дамаскт олон жил амьдарчээ. Дайны дараа СС-ийн маш олон цэргийн гэмт хэрэгтнүүдийг “Цагаачлалын асуудлаархи Араб-Германы төв” гэгчийн шугамаар тэр хамба Ойрх Дорнод руу шингээсэн юм. Фельдмаршал Роммелийн албат хурандаа Ханс Мюллер гэгч энэ төвийг байгуулаад хамбын Каир дахь албан конторт байрлаж байв. Тэрээр лалын шашинт сирийн иргэн Хосан Бей гэгч нэрээр олон жил эсэн мэнд явсан юм. 1950-иад онд арабын орнуудад Вермахт, Гестапогийн 8000 орчим офицер бүгж байсан баримт байдаг. Израиль улс байгуулагдсаны дараа дээрхи муфтий Каирт байхдаа нацистуудыг Египет рүү олноор нь оруулж бүгүүлэх үйлсийг санаачилсан ба лалын энэ хамбын буянаар Вермахт, Гестапо, СС-ийн олон офицер арабын армиудад хөлсөөр ажиллах болжээ.

Гитлерийн генерал Фармбахер тэргүүтэй 60 офицер ажилладаг германы албан бус цэргийн төлөөлөгчийн газар Египетэд 1951 он гэхэд ажиллаж байв. Тэд египетийн арми, цагдааг сургаж бэлтгэх сургалтыг хариуцаж, II дайны үед Украинд яргалал үйлдэж асан СС-ийн алуурчин Оскар Дирлевангер гэгч нь Насерын тушаалаар египетийн десантчдыг сургаж бэлтгэн Израиль руу илгээж байв. Алдарт Отто Скорцени Насерын дэргэд зөвлөхөөр нь ажиллаж, тус улсын улсыг аюулаас хамгаалах албыг нь бэхжүүлж байв. Египетийн улсыг аюулаас хамгаалах албаны суртал нэвтрүүлгийн хэлтсийг СС-ийн обергруппенфюрер Мозер гэгч Хусса Налисман гэсэн араб нэрээр толгойлж, Египетийн төрийн нууц цагдаагийн газрыг Гестапогийн группенфюрер Генрих Зельман гэгч Хамид Сулейман гэсэн нэрээр удирдав.

Геббельс, Розенбергийн албат, расист онолыг сурталчлагч, “Вилле унд тат” гэх нацист сэтгүүлийн ерөнхий редактор Иоханн фон Леерс гэгчийг энд зориуд нэрлэх хэрэгтэй. Тэрээр хожим лалд орж, араб хэлэнд нэвтэрч 1956 он гэхэд Ойрх Дорнодын нацистуудын үйл ажиллагааны гол зохицуулагч болсон байлаа. Дайны дараа нь Леерс нь Аргентинд дарангуйлагч Пероны албанд зүтгэжээ. Тэгснээ Каирт нацистын цэргийн гэмт хэрэгтнүүдийг

цуглуулах ажилд шилжив. Түүнд зартай нацист Ханс Апплер буюу Лалын конгрессын нарийн бичгийн дарга Салаб Гафа гэх нөхөр шадарлан туслав. Леерс нь тухайн үедээ Египетийн Үндэсний хөгжлийн яамны зөвлөхөөр ажиллаж байв. Араб дорно дахинд нацизмын үзэл санааг дэлгэрүүлэх ажилд Риббентропын албаны араб дахины мэргэжилтэн барон фон Мильденштейн гэгч Леерсийн хамт зүтгэсэн байдаг юм.

“Холокост” хэмээх яргалалаа нацистууд Египет болон арабын зарим оронд дэлгэрүүлэхийг зорив. Хорих лагериар мэргэжсэн герман мэргэжилтнүүд шорон, гяндангуудыг олноор байгуулж, сөрөг хүчнийхнийг эрүүдэн шүүдэг өвөрмөц арга барилаа арабчуудад өвлүүлэв. Цэргийн гэмт хэрэгтэн доктор Эйзеле 1958 онд Каирт хүндэт зочноор морион, СС-ийн эмч Виллерман Александриа хотын ойролцоох хорих газрын эмнэлгийн ангийг толгойлж байв.

Египет, Палестин, арабын хэд хэдэн улсад нацист ном зохиол, юуны өмнө Mein Kampf өргөн тархаж судлагдаж, сурталчлагдаж байлаа. Дайны үед Каирт Германы мэдээллийн албыг толгойлж байсан нацист Эль-Хаж буюу жинхэнэ нэр нь Гейден гэгч нацист ном зохиолын гол түгээгчээр 1950-иад оны турш ажиллав. “Дойче националь-цайтунг” сонины 1959 оны нэг дугаарт мэдээлснээр, Каирын зөвхөн нэг номын мухлагт ганцхан өдөрт араб хэл дээрхи Mein Kampf 1000 ширхэг борлуулагдаж, ихэнхи уншигчид нь египетийн армийн офицерууд байжээ. Леерс нацистуудыг каирын радиод олноор нь шургалуулав. 1958 онд “Нью-Йорк таймс мэгэзин” сэтгүүлийн нэг дугаарт бичсэнээр Израилийн эсрэг нацист суртал нэвтрүүлгийн маш хүчирхэг зэвсэг нь каирын радио болж хувирчээ гэх мэт баримтууд зөндөө байна.

Томчуудаас ганц Г.Насер, А. Садат нар фашист үзэл санааг дэмжээд байсан бус Саудын Арабт нацизм, ваххабизм хоёр хоёр талаасаа угталцан золгосон баримт бас байна. Оргож очсон нацистууд ваххабитуудтай холбогдон, шашны догмыг нь улс төр-цэргийн үзэл санаа болгон шат ахиулжээ. “Лалын жинхэнэ хамгаалагчид”-ын цэргийн сургалтын төвүүдийг СС-ийн офицерууд байгуулж өгснөөр

“арабын террористууд” түүхнээ буй болжээ. Саудын Арабын сэтгүүлч Вайди аль-Газзави гэгч зурагтаар ярихдаа энэ улсад терроризм, “Аль-Каеда” хоёр анх үүссэн¹⁰ хэмээн эх орноо нэр заан шүүмжилснийхээ төлөө 12 жилийн ялаар заагдаж Ван Абдулладаа тэрсэлсэн болж таарсан нь нэгийг хэлэх мэт.

Сирид Гитлерийн жанжин штабын хурандаа Крибль, Гестапогийн офицер Рапп нар Сирийн армийг эмхлэн зохион байгуулах ажлыг гардсан юм. Тэд израилийн эсрэг үзэлт үндсэрхэг үзэлтнүүдтэй нийлэн хэд хэдэн удаа төрийн эргэлт хийхэд оролцсон ба Рапп нь 1949 онд Дамаскт цэргийнхний үймээнийг удирдаж байв. Сири дэх генерал Шишеклийн дэглэмийн үед нацистууд Сирийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэв. Шишеклийн дэргэд 11 нацистаас бүрдсэн цэргийн зөвлөхүүдийн бүлэг ажиллаж, арабын бүх улсыг нэгтгэх төлөвлөгөө гэдгийг хэрэгжүүлж байв.

Иракт 1958 онд хаант засгийг түлхэн унагасны дараа Бүгд найрамдах улсын шинэ Засгийн газарт “Бранденбург” хэмээх гитлерийн дивизийн нэг офицер Жабр Омар нэрээр Гэгээрлийн сайдаар томилогдон ажиллав. Нацист Германы тагнуулын албаны агент байсан Саддик Шаншал Үндэсний барилгажилтын сайдаар томилогдов. ХБНГУ-д хожим германы Баадер-Майнхоф террорист байгууллага гарч ирснээр палестины террористууд тэдэнтэй хамтран ажиллах болжээ.

Нурж унасан Рейхийн дүрвэсэн нацистууд арабчуудыг ийнхүү цэнэглэн байсан бол ялсан СССР-ийн коммунистууд палестины

еврейчүүдийн талд эхний үед баттай зогсож байлаа. Ерөөсөө Израиль улс байгуулна гэдэг нь анхлан Москвагаас гарсан санаа аж. Нацистууд арабчуудыг зэвсэглэж сурган жүүдүүдийн эсрэг тулалдуулсан бол дөнгөж байгуулагдсан израилийн армид тусламжийн гараа Москва сунгажээ. Улаан арми дахь өдий төдий еврей дайчид сайн дурын цэрэг болж Израилийг зорихоор бүртгүүлж, израилийн офицерууд Зөвлөлтийн цэргийн академиудад суралцахаар түрүүчээсээ ирж байв. Чехословак, Унгараар дамжуулан зөвлөлтийн зэвсэг Израиль руу цувж, Прагад Готвальдын бригад нэрээр Израилийн батлан хамгаалахын ирээдүйн дарга нар зөвлөлт сургагчдынхаа номын дууг сонсов. Гэвч Израиль Улс социализмын замаар замнахгүй нь тодорхой болмогц нацистуудын үнэнч шавь Насерыг Зөвлөлт өөртөө татаж эхэлсэн түүхтэй.

Нацизмаар тархиа угаалгасан Насер Зөвлөлт Холбоот Улсын Баатар болмогц коммунизм руу эргэсэн гэдэг нь юу л бол? Түүний орлогч, залгамжлагч Садатын түүх шал өмнөөг өгүүлнэ. Хоёрдугаар дайны үед Садат германы талд тагнуул хийж яваад баривчлагдан английн гянданд хоригдсон, 1953 онд египетийн “Аль Мусаввар” сэтгүүлд нас барсан Гитлерт зориулан Садатаас бичсэн захидал нийтлэгдсэн, түүнд “Миний хайрт Гитлер ээ. Би сэтгэл зүрхний угаас чамдаа баяр хүргэж байна. Нийтийнхний үзэж байгаагаар чи одоо дайнд ялагдаад байна. Гэвч жинхэнэ ялагч нь чи мөн. Хуучны егзөр Чөрчилль, түүний холбоотон шулмасын зулбадас хоёрын дунд чи шаантаг болон зоогдож байсан билээ” гэжээ.

Зургаа. Дүгнэлтийн оронд

Дээрхи түүхэн оршлыг орчин үетэй хэрхэн холбох вэ? Ойрх Дорнодод бол ойгомжтой. Жүүдийн төр улсын эсрэг арабчуудын экстремизм нацизмын үзэл суртлаар тэжээгдэн амилсаар байна. Гэтэл соёлжсон Европ?

Аль-Каеда хамгийн амжилттай яваа бүс нутгийн дотор саяхан Европ нэрлэгдсэн нь гайхалтай ба эмзэглэмээр. Францад 5000–8000

ваххабит, салафит байна гэвэл Та итгэх үү? Өрнөд Европын соёлын ууган өлгий энэ нутагт лалын радикализм яаж яваад үүрлэх нь энэ вэ? Тэднээс лав хэдэн зуу ньжихад явуулна гэж ил зарласнаасаа болоод францын тусгай албадын ажиглалт, хяналтад байгаа гэж байна.

¹⁰ “Saudi Journalist Jailed 12 Years for ‘Disobeying Ruler,’” *The Daily Star*, February 4, 2014

Иран гаралтай франц эрдэмтэн социологч Фархад Хосрохаварын¹¹ тайлбар байна. Исламизмд залуус яагаад тархиа угаалгадаг хийгээд түүний хор уршгийн талаархи сэдвийг хөнджээ. Түүний үзэхээр бол, Европ дахь лалын радикалууд дүрсээ хувилгаж байгаа юм байна. Өмнө нь гадна төрх, сахал үс, залбирал мөргөл, бардам яриагаар нь фундаменталист гэдгийг нь таниад болдог байж. Харин одоо тиймүүд нь нам гүм болж, хэн хаана юу хийж явдаг нь нууц байдалд шилжсэн нь маш ноцтой гэнэ. Ах дүүс нь хүртэл танихгүй явж байгаад хэрэг хийснийх нь дараа мэл гайхах энүүхэнд. Ийнхүү шинэ радикалууд танигдахаа байснаас тусгай албад үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учирчээ. Эмчийн хяналтад байх ёстой сэтгэхүйн тэнцвэрээ алдсан хүмүүс бол чухам экстремист үзэл суртлын өгөөш нь аж.

1970-1980-аад онд хэт зүүний зэвсэгт бүлэглэл Францад “Шууд үйл ажиллагаа”, Италид “Улаан бригад” нэрээр нийгмийг түгшээж байсан бол эдүгээ лалын фундаментализм Баруун Европыг айдаст автуулж эхэлжээ. Хотуудын ядуусын хороололд антиимпериалист тэмцэгч ислам үүрлэж, дарлагдсан ядуурсан бүх хүнд лал л тусална гэх суртал эрчээ авчээ. Ер нь л дарлагдсан ард түмний гол шашин гэх шахуу яригддаг болж. Эр эм хоёрыг тэгш эрх эдлүүлдэг өрнийн феминизм лалтай шууд харшиллаа. Тэгснээр радикализм хөгжих бас нэг өгөөш гараад ирлээ. Шорон гэж радикал исламизм хөгжих сайхан орчин байна. Жирийн эрүүгийн хэрэгтэн шоронд хоригдоод гарч ирэхдээ исламист болчих нь Европт бараг хэвшмэл үзэгдэл боллоо хэмээн эрдэмтэн Хосрохавар анхааруулжээ. Энд би Аль-Каеда амжилттай яваа Европын нууц руу л орох гэхдээ л иран гаралтай франц эрдэмтнээс эшлэж байна.

Жиль Кепель гэж франц судлаач өөр тайлбар хэлж байна. Түүний “Бүгд найрамдах улсын дагуул хот” (“Banlieue de la République”) номд

бичээтэй байна. Хотын захын дундаж давхаргынхан ажилгүйдэж байгаа нь радикал исламизм хөгжих бас нэг таатай нөхцөл аж. Ядуурал ажилгүйдэл нь яалт ч үгүй залуу европчуудыг мусульманы коммюнити руу хандуулдаг гэсэн байх юм. Тэгэхлээр ийм ил далд элдэв явууллагад хүргэхгүйн тулд Францын төр исламыг албан ёсоор төрийн шашин хэмээн хүлээн зөвшөөрөөд, төрөөс залж чиглүүлж байя гэх санал дэвшүүлсэн¹² нь европчууд цөхрөнгөө барсных гэж үзмээр юм шиг.

Европт одоо бугшиж буй XXI зууны лалын экстремизм, өнгөрсөн зууны нацизмын хоорондын адил талыг олж харж ажигласан Ришар Праскье гэж франц зүтгэлтний тайлбар байна. Тэрээр Францын жүүдийн байгууллагуудын зөвлөлийн дарга аж. Радикал исламизм, нацизм хоёр ингэж дуу дуугаа авалцах гэж дээ¹³ хэмээн шогширч ирээд л бичсэн байх юм. Тэрээр Елисейн ордонд 2012.10.07-нд очиж, Ерөнхийлөгч Франсуа Олландад энэ үгээ хэлсэн байх ба цаадхи нь тэгтлээ шимтээгүй бололтой. Биднийг үхэл рүү хөтлөх үүрэг бүхий маш олон идэвхтэнүүдээс бүрдсэн лалын үүр хороод Франц даяар унтаж байна шүү хэмээн тэрээр бүр анхааруулсан гэв.

Нацистын үед аж төрж, жүүдүүдийг хэрхэн хомроголож, алж талж байхыг харсан ахмад настан эдүгээ Францад олноороо бий. Радикал исламизм, нацизм хоёрыг харьцуулаад ирэхтэй зэрэг тэд гайхаж зарим нь шооконд орсон гэж байна. Зарим нь огт хүлээн аваагүй бололтой. Тэнэг яриа байна гэсэн хүн ч гарсан гэнэ. Хүн төрөлхтөний түүхэнд хийсэн ялт үйлдлээрээ нацистуудын дээр гарсан өөр “изм” байхгүй гэж ч хариулсан юм байх. Харгислалын тоо хэмжээний тухайд бус үзэл суртлыг нь Праскье адилтгасан болж эцэстээ тэр яриа тасарсан бололтой. Гэхдээ тэр ярьсангүй цаасан дээр буулгажээ. Нэгэнт л дайснаа өршөөхгүй, устгаж

¹¹ Farhad Khosrokhavar, “Des ‘dizaines de Merah et de Kelkal en France’ : comment ramener à la raison un individu sur le point de sombrer dans le jihad?,” *Atlantico*, January 23, 2013, <https://atlantico.fr/article/decryptage/des-dizaines-de-merah-et-de-kelkal-en-france---comment-ramener-a-la-raison-un-individu-sur-le-point-de-sombrer-dans-le-jihad--farhad-khosrokhavar>

¹² Gilles Kepel, *Banlieue de la République*, Institut Montaigne, October 2011, <https://www.institutmontaigne.org/publications/banlieue-de-la-republique>

¹³ Richard Prasquier, “Oui, l’islamisme radical et le nazisme sont deux idéologies comparables,” *Le Monde*, October 17, 2012, https://www.lemonde.fr/idees/article/2012/10/17/oui-l-islamisme-radical-et-le-nazisme-sont-deux-ideologies-comparables_1776739_3232.html

байж салах л юм бол улс төрийн ислам, нацизм хоёр юугаар ялгаатай юм бэ? Жишээ болгож салафизмыг авч үзье. Одоогоор салафизм Европт номлол төдий байна, хэрэв шүтэн бишрэгчдийг нь зэвсэглэхивэл нацистуудаас юугаараа ялгарах вэ?

Нацизм, радикал исламизм хоёрыг нэгтгэх хоёр хүчин зүйл байна. Эхнийх нь хоёулаа жүүдүүдийг тэргүүлэх дайснаа гэж үздэг, хоёр дахь нь өршөөлгүй, хүнлэг бус чанар нь. Орчин үеийн антисемитизм буюу жүүдүүдийг үзэн ядал үзлийн тодорхой жишээ нь ХАМАС-ын Харти дахь дараах үгс: Цаг нь болоогүй байна. Мусульманчууд жүүдүүдийг хараахан ялаагүй байна. Жүүдүүдийг алж эхлээгүй байна. Гэвч тэднийг мөшгөсөөр байх болно¹⁴ гэх нь антисемитизм өнөөдөр радикал исламизмын гол үзэл суртал, өнгөрсөн үед нацизмын гол үзэл суртал байсны илэрхийлэл бус уу? Нацистууд жүүдүүдийг жоом, харх, бактер нян, хордуулагч гэж нэрлэж байсан бол өнөөдөр радикал исламистууд жүүд, христианчуудыг

хамтруулаад сармагчин, гахай, илжиг, нохой гэх нь юуны ялгаа байна¹⁵ хэмээн Праскье асуужээ.

Бусад улс үндэстнийг зоологийн үүднээс тодорхойлж үзэн ядах нь радикал үзэл онол, радикал шашны номлогчдод түгээмэл байх үзэгдэл аж. Дайсан л гэж үзсэн бол нярай балчир, өтгөс өвгөд, эр эм хамаагүй. Нацизм, радикал исламизм хоёрт яадгаа алдсан фанатик алуурчин гэж байхгүй, тэд үзэл суртлаар тархиа угаалгаад хийж байгаа үйлдэл нь тэр. Нэг нь Аллахын нэрийн өмнөөс, нөгөө нь Фюрерийн нэрийн өмнөөс. Судлаач Праскье авгайн байр суурь ердөө энэ. Энд миний дэвэргэж бичсэн мөр гэж байхгүй.

“Арабын национализм, нацизмын хооронд зарчмын ялгаа байхгүй, Г.А.Насерын үндэслэсэн арабын национализм бол европын фашизмын Ойрх Дорнод хувилбар нь”¹⁶ хэмээн Бейрутын их сургуулийн хуулийн профессор Шибли Малла бичсэнийг энд дурдах нь зүйтэй.

Ойрх Дорнодод бугшсан радикал исламизмын зураглал ийм буюу!

Ном зүй / References:

1. “Арабская демократия — это миф, арабский фашизм — реальность.” *МАОФ*. March 14, 2005. <https://maof.rjews.net/>
2. Geller, Pamela. “The Muslim Hitler, Haj Amin al-Husseini, Was Promised Leadership of Israel [Palestine] After Annihilation of the Jews.” *Atlas Shrugs*. December 2010. <https://pamelageller.com/2010/12/>
3. Irving, David. “Did Himmler Ever Admit to ‘Three Million’?” *Focal Point Publications*. Accessed June 2, 2026. https://fpp.co.uk/Himmler/Judenfrage/Mufti_memoirs.html
4. Jewish Community Relations Council. “Backgrounder on the Issues — HAMAS: Its Ideology and Record.” July 2008
5. Kepel, Gilles. *Banlieue de la République*. Institut Montaigne, October 2011. <https://www.institutmontaigne.org/publications/banlieue-de-la-republique>
6. Khosrokhavar, Farhad. “Des ‘dizaines de Merah et de Kelkal en France’: Comment ramener à la raison un individu sur le point de sombrer dans le jihad?” *Atlantico*. January 23, 2013. <https://atlantico.fr/article/decryptage/des-dizaines-de-merah-et-de-kelkal-en-france----comment-ramener-a-la-raison-un-individu-sur-le-point-de-sombrer-dans-le-jihad--farhad-khosrokhavar>
7. “‘Nazism, Islam Shared Common Enemies — the Jews.’” *The Jerusalem Post*. December 15, 2010. <https://www.jpost.com/international/nazism-islam-shared-common-enemies-the-jews/article-199451>

¹⁴ Jewish Community Relations Council, “Backgrounder on the Issues — HAMAS: Its Ideology and Record,” July 2008

¹⁵ Richard Prasquier, “Oui, l’islamisme radical et le nazisme sont deux idéologies comparables,” *Le Monde*, October 17, 2012, https://www.lemonde.fr/idees/article/2012/10/17/oui-l-islamisme-radical-et-le-nazisme-sont-deux-ideologies-comparables_1776739_3232.html

¹⁶ “Арабская демократия — это миф, арабский фашизм — реальность,” *МАОФ*, March 14, 2005, <http://maof.rjews.net>

8. Prasquier, Richard. “Oui, l’islamisme radical et le nazisme sont deux idéologies comparables.” *Le Monde*. October 17, 2012. https://www.lemonde.fr/idees/article/2012/10/17/oui-l-islamisme-radical-et-le-nazisme-sont-deux-ideologies-comparables_1776739_3232.html
9. Roberts, Sam. “Declassified Papers Show U.S. Recruited Ex-Nazis.” *The New York Times*. December 11, 2010. <https://www.nytimes.com/2010/12/12/us/12holocaust.html>
10. “Saudi Journalist Jailed 12 Years for ‘Disobeying Ruler.’” *The Daily Star*. February 4, 2014
11. Vermaat, Emerson. “Haj Amin Al-Husseini — Nazi Collaborator and Model for Today’s Islamists.” *Militant Islam Monitor*. February 27, 2008. <https://www.militantislammonitor.org/article/id/3381>

National socialism & radical islamism

Bayarkhuu Dashdorj

Professor

International relations scholar

Ulaanbaatar, Mongolia

bayardevi@hotmail.com

Abstract: This article will tell the story of how Nazi German ideology was connected to Arab Islamic extremist ideology, and how Nazis and Muslim extremists collaborated on that ideology. The ideology of Nazi Germany is strong in the Arab world today. Because they both hate Jews and want to destroy the State of Israel, it is one of the sources of their terrorist ideology. The joint US-Israeli military operation against Iran and its proxy Hezbollah today is a legitimate fight against Islamic extremism and terrorism, which was firmly rooted in the ideology of radical Arab Islam during World War II. This was reported by researcher-professor Dashdorj Bayarkhuu, based on facts. Professor D. Bayarkhuu is a career diplomat who served as ambassador to the Arab Republic of Egypt, Kuwait, Saudi Arabia, and Iran.

Keywords: Nazi ideology, Arab Islamic extremism, Middle East, terrorism

The date of submission:	2026.03.28
Completion of review:	2026.05.11
Final decision for acceptance:	2026.05.29